# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

*Улаанбаатар хот* *2000 оны нэгдүгээр сарын 15* *№2 (140)*

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

6. Онцгой албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай (2000-1-06-ны хууль) 18

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

7. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Дугаар 01 18
8. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2000 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Дугаар 02 18
9. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2000 онд баримтлах чиглэл батлах тухай Дугаар 03 38
10. Монгол Улсын 1998 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Дугаар 04 39
11. Парламентын музейг үндэслэн байгуулах тухай Дугаар 05 39

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

12. Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай Дугаар 214 40
13. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 215 40
14. Цэргийн нийтлэг дүрмүүд батлах тухай Дугаар 216 43
15. Зарим хүнийг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 217 43
16. Далелханы Есболыг "Шударга журам" медалиар нэхэн шагнах тухай Дугаар 218 43
17. Зарим шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай Дугаар 219 44
18. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 220 44
19. Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 01 44
20. Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай Дугаар 02 44

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**2000 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр** **Улаанбаатар хот**

### ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Онцгой албан татварын хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"4.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 5-д заасан импортын суудлын автомашинд түүний үйлдвэрлэгдэн гарснаас хойших хугацааг харгалзан автомашин тутамд дараах хэмжээгээр /ам.долларт шилжүүлснээр/ онцгой албан татвар ногдуулна:

| Үйлдвэрлэгдэн гарснаас хойших хугацаа | Татварын дүн |
|---|---|
| 0-3 жил | 500 |
| 3-аас 10 жил | 1000 |
| 10-аас дээш жил | 2000 |

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2000 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2000 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр** **Дугаар 01** **Улаанбаатар хот**

### Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорьдугаар зүйл, жаран есдүгээр зүйлийн 1, 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд Монгол Улсын Ерөнхийлөгчөөс бүхэлд нь тавьсан хоригийг хүлээн авах боломжгүй гэж үзсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2000 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр** **Дугаар 02** **Улаанбаатар хот**

### Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2000 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Засгийн газрын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2000 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хавсралт ёсоор баталсугай.

2.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2000 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг оны эхнээс жигд хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах, хэрэгжилтийн явцыг улирал тутам дүгнэн хэлэлцэж байхыг Засгийн газар /Р.Амаржаргал/, Монголбанк /Ж.Үнэнбат/, Үнэт цаасны хороо /Ж.Ядамсүрэн/-нд үүрэг болгосугай.

3.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн өөрсдийн үйл ажиллагаанд холбогдох заалтын биелэлтийг улирал, хагас жил, бүтэн жилээр гаргаж, дараа сарын 10-ны дотор Засгийн газарт ирүүлж байхыг Монголбанк, Үнэт цаасны хороо, Үндэсний статистикийн газарт үүрэг болгосугай.

4.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2000 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн байдлыг оны эхний хагас жил болон бүтэн жилээр гаргаж 2000 оны 7 дугаар сар, 2001 оны 2 дугаар сард Улсын Их Хуралд танилцуулахыг Засгийн газар /Р.Амаржаргал/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **Р.ГОНЧИГДОРЖ**

*Монгол Улсын Их Хурлын 2000 оны 02 дугаар тогтоолын хавсралт*

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2000 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| Бодлогын агуулга, зорилт | Бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хэрэгжүүлэх эзэн |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| | ***А.Макро эдийн засгийн тогтворжуулалт*** | | |
| 1.Эдийн засгийн өсөлтийг хангах, макро эдийн засгийн таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн төсөв, мөнгөний зохистой бодлого явуулна. | -Макро эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрт байдал болон гадаад орчны өөрчлөлтөд тогтмол судалгаа хийж, бодлогын зохицуулалтыг тухай бүр хийж байх | жилдээ | Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч |
| • Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 4.0 хувьд хүргэх | -Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх бизнесийн таатай орчин бүрдүүлэх, ялангуяа санхүү, банкны бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх, гадаадын зээл, тусламжийг дэд бүтэц, боловсролын салбарт түлхүү ашиглах | жилдээ | Сангийн сайд |
| | -Мөнгөний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах зохицуулалтыг оновчтой хэрэгжүүлэх үүднээс нийт мөнгөний нийлүүлэлтийг 20 хувиас хэтрүүлэхгүй байх, бэлэн бус тооцооны арга хэрэгслийг өргөн нэвтрүүлэх | жилдээ | Монголбанкны Ерөнхийлөгч |
| | -Том үйлдвэрийн газрыг хувьчлах замаар үндэсний эдийн засаг дахь хувийн хэвшлийн хүрээг өргөжүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| • Инфляцийн түвшинг 15 хувиас хэтрүүлэхгүй байх | -Банкны байгууллагаас Засгийн газарт олгох цэвэр зээлийн хэмжээг дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувиас хэтрүүлэхгүй байх үндсэн дээр хувийн хэвшилд ногдох дотоод санхүүжилтийн эх үүсвэрийн зохистой харьцааг хангах | жилдээ | Сангийн сайд |
| •Гадаад валютын цэвэр нөөцийг 95.0 сая ам.доллар буюу 10 долоо хоногийн импортын бараатай тэнцэх хэмжээнд байлгах | -Гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, экспортын чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээг урамшуулах хөшүүргийг бүрдүүлэх | жилдээ | Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч |
| •Ажилгүйдлийн түвшинг эдийн засгийн идэвхтэй хүн амын 5 хувиас хэтрүүлэхгүй байх | -Хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, ядуурлыг бууруулах хөтөлбөрийг ажлын байр шинээр бий болгоход чиглүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн тогтолцоог сайжруулах, хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлого явуулах | жилдээ | Эрүүл мэнд, нийг-мийн хамгааллын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | ***Төсөв, татварын бодлого*** | | |
| 2. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх төсвийн алдагдлыг 10 хувиас хэтрүүлэхгүй байлгаж, урсгал төсвийн ашгийг 1.0-ээс доошгүй хувьд хүргэнэ. | -Татварын орлогын бааз суурийг өргөжүүлэх, экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн уналтыг саармагжуулах, төсвийн нийт зарлагыг оновчтой зарцуулах хөшүүргийг бүрдүүлэх | жилдээ | Сангийн сайд |
| | -Татварын бодлогыг татварын нийт дарамтыг хязгаарлах, татварын тогтолцооны гажуудлыг арилгахад чиглүүлэх, хялбаршуулсан орлогын албан татварын систем нэвтрүүлэх | тухай бүр | Сангийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | ***Мөнгө, зээл, ханшны бодлого*** | | |
| 3. Үнэ, ханшны тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтөд чиглэсэн мөнгөний бодлого явуулна. | -Мөнгөний арга хэрэгслүүдийг ашиглан мөнгөний нийлүүлэлтийг үнийн өсөлт, ханшны хэлбэлзэл, улирлын өөрчлөлттэй тухай бүр уялдуулан зохицуулах | тухай бүр | Монголбанкны Ерөнхийлөгч |
| | -Үнийн өөрчлөлтийн байдалд нийцүүлэн бодит хүүг зэрэг түвшинд байлгахын зэрэгцээ бодит эдийн засгийн өсөлтийг тэлэх орчин бүрдүүлэх | жилдээ | Монголбанкны Ерөнхийлөгч |
| | -Зах зээлийн зарчимд үндэслэсэн валютын ханшны тогтолцоог хэвээр хадгалж, гадаад худалдааны нөхцөлийн өөрчлөлт, зах зээлийн ханшны огцом хэлбэлзэлтэй уялдуулан бодлогын зохицуулалт хийж байх | тухай бүр | Монголбанкны Ерөнхийлөгч |
| 4.Банкны салбарын бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлж, банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагааг эрүүлжүүлэх дэс дараатай арга хэмжээ авна. | -Арилжааны банкны хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр хууль эрх зүйн орчинг сайжруулж, хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах | жилдээ | Монголбанкны Ерөнхийлөгч |
| | -Санхүүгийн зуучлалын хүрээг өргөтгөх зорилгоор төрөлжсөн үйл ажиллагаа бүхий санхүүгийн компани, банкны бус санхүүгийн байгууллагууд хөгжих хууль эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх, мөрдөж буй журам, зааврыг боловсронгуй болгох | жилдээ | Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд |
| | -Өр барагдуулах талаар тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж, зээлийн орийн үлдэгдлийг багасгах, түүнд хугацаа хэтэрсэн болон хэвийн бус, эргэлзээтэй, найдваргүй зээлийн эзлэх хувийн жинг бууруулж нормативт хэмжээнд нь хүргэх | жилдээ | Монголбанкны Ерөнхийлөгч |
| | -Банкууд хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр зохион байгуулагдан ажиллах эрх зүйн орчин бүрдүүлэх | II улирал | Монголбанкны Ерөнхийлөгч |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Банкинд бүтцийн өөрчлөлт хийхтэй уялдуулан банкыг өөрчлөн байгуулах зарчмыг тогтоож мөрдүүлэх | I улирал | Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд |
| | -Үйл ажиллагаа нь доройтож, санхүү төлбөрийн чадвар нь хүндэрсэн банкинд хариуцлага хүлээлгэх, албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх | I улирал | Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд |
| | -Бүтцийн өөрчлөлтийн хүрээнд Хөдөө аж ахуйн банкийг төр мэдэлдээ түр хугацаагаар байлгаж, үйл ажиллагааг нь хэвийн явуулах зорилгоор Монголбанк, Засгийн газраас дахин хөрөнгөжүүлэх арга хэмжээ авах, төлбөрийн чадвар нь сайжирсны дараа хувьчлах | жилдээ | Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд |
| | -ХОТШ, Сэргээн босгоолт банкуудад бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, хувийн хэвшилд тулгуурласан хэлбэрээр өөрчлөн байгуулах | жилдээ | Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд |
| | ***Б.Бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх чиглэл*** | | |
| 5.Зах зээлийн эдийн засгийн харилцааг төлөвшүүлэх, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн бүтцийг бий болгох чиглэлээр шинэчлэлийг улам гүнзгийрүүлж, өмч хувьчлалыг эрчимжүүлнэ. | -Эдийн засагт нөлөө бүхий улсын томоохон аж ахуйн нэгжүүдийг зохих бэлтгэлийг хангасны үндсэн дээр хувьчлах замаар өмч хувьчлалаас 9 тэрбум төгрөгийг төсөвт оруулах | жилдээ | Сангийн сайд |
| | -Олон улс, орон нутгийн нислэгийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор иргэний агаарын тээврийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг зах зээлийн харилцаанд нийцүүлэн өөрчлөх чиглэл боловсруулан хэрэгжүүлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Түлш, эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлт хийх эрх зүйн орчин бүрдүүлэх, бүтцийн өөрчлөлтийг хэрэгжүүлж эхлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Холбооны салбарт бүтцийн өөрчлөлт хийх, хувьчлахтай холбогдуулан хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Эрчим хүчний үйлдвэрүүдийн техник технологийн шинэчлэлийг үргэлжлүүлэхийн зэрэгцээ салбарын бүтэц, удирдлага, зохион байгуулалтыг зах зээлийн нөхцөлд нийцүүлэн өөрчлөн зохион байгуулах | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Түлш, эрчим хүчний салбарын үйлдвэрүүдийг аж ахуйн бие даасан хэлбэрт шилжүүлэн зохион байгуулах, тэдгээрийн хоорондын санхүү, эдийн засгийн | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | хариуцлагын тогтолцоог бий болгох замаар үр ашигтай ажиллуулах механизмыг бүрдүүлж, өр авлагыг бууруулах | | |
| | -Төвийн болон орон нутгийн нүүрсний уурхайнуудын техник, технологийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлж, салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, түлшээр дутмаг бүс нутгийн түлшний хангамжийг сайжруулах | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын хувьчлалын хөтөлбөр, холбогдох бусад баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Төрийн өмчийн болон төрийн өмчийн орол-цоотой барилгын байгууллагыг хувьчлах, барилгын норм, стандарт, дүрмийг зах зээлийн харилцааны шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Төрөөс орон сууцны талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, орон сууц хөгжүүлэх сан байгуулах, төрийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын орон сууцыг хувьчлах, сууц өмчлөгчдийн холбоодын үйл ажиллагааг тогтмолжуулах, дэмжих арга хэмжээ авах | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| 6.Үнэт цаасны зах зээлийг зохицуулах хууль тогтоомжийг боловсронгуй болгож, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ | -Үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Хөрөнгө оруулалтын компанийн тухай, Итгэмжлэлийн тухай хууль боловсруулах | I-II улирал | Үнэт цаасны хорооны дарга<br>Хууль зүйн сайд |
| | -Үнэт цаасны тухай болон Компанийн тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж холбогдох журам, зааврыг шинэчлэн мөрдүүлэх | I улирал | Үнэт цаасны хорооны дарга,<br>Хууль зүйн сайд |
| | -Хамтын хөрөнгө оруулагчдад зах зээлийн харилцааны дагуу үйл ажиллагаа явуулах тааламжтай орчин нөхцөлийг бүрдүүлэх | II улирал | Үнэт цаасны хорооны дарга |
| | -Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах арга хэмжээг тухай бүрд нь авч хэрэгжүүлэх | жилдээ | Үнэт цаасны хорооны дарга,<br>Сангийн сайд |
| 7.Өмч хувьчлалыг үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх асуудалтай уялдуулан хэрэгжүүлнэ. | -Үнэт цаасны зах зээлийг өргөжүүлэхэд өмч хувьчлалыг оролцоог нэмэгдүүлэх асуудлыг судалж, бодлогын хувьд уялдуулах санал боловсруулж хэрэгжүүлэх | III улирал | Үнэт цаасны хорооны дарга |
| | -Хувьчлалыг биржээр дамжуулан явуулж эхлэх, төрийн | жилдээ | Үнэт цаасны хорооны |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | мэдлийн хувьцааг биржээр худалдах | | дарга, Сангийн сайд |
| | -Гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг Монгол Улс руу татах эрх зүйн нөхцөлийг бүрдүүлж, зохион байгуулалтын арга хэмжээ авах | жилдээ | Үнэт цаасны хорооны дарга, Хууль зүйн сайд |
| 8.Үнэт цаасны эрэлт, нийлүү-лэлтийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих таатай орчин бүрдүүлж, үнэт цаасны зах зээлийг бэхжүүлнэ. | -Компаниуд шинээр болон нэмж үнэт цаас гаргах замаар хөрөнгө оруулалт хийх явдлыг урамшуулах хөшүүргийг бий болгох, хөхүүлэн дэмжих | жилдээ | Үнэт цаасны хорооны дарга |
| | -Засгийн газрын урт, богино хугацаатай хөрвөх чадвар бүхий үнэт цаасыг зах зээлд арилжаалж эхлэх | жилдээ | Үнэт цаасны хорооны дарга<br>Сангийн сайд |
| | -Компаниуд бүх төрлийн үнэт цаас гаргах, түүний хөрвөх чадварыг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх | жилдээ | Үнэт цаасны хорооны дарга, Сангийн сайд |
| 9.Үнэт цаасны зах зээлийн талаар явуулах сургалт, сурталчилгааг сайжруулна. | -Хөрөнгийн зах зээлийн талаар радио, телевиз, өдөр тутмын хэвлэлээр сургалт, сурталчилгаа явуулах | жилдээ | Үнэт цаасны хорооны дарга |
| | -Олон нийтэд зориулсан семинар, уулзалтууд зохион байгуулах | жилдээ | Үнэт цаасны хорооны дарга |
| | -Үнэт цаасны чиглэлээр ажиллах боловсон хүчин бэлтгэх, давтан сургах | жилдээ | Үнэт цаасны хорооны дарга |
| | ***В. Үйлдвэрлэл, үйлчилгээг сэргээн хөгжүүлэх бодлого, чиглэл*** | | |
| 10.Үндэсний үйлдвэрийг сэргээх, экспортын баримжаатай эдийн засгийн бүтцийг бий болгоход чиглэсэн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | -Экспортын үйлдвэрлэлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд "Монгол ноолуур", "Монгол ноос", "Монгол арьс шир" зэд хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, Сангийн сайд |
| | -Махны экспортыг дэмжих төсөл хэрэгжүүлэх, мах боловсруулах үйлдвэрүүдийн техник, технологийг олон улсын стандартын түвшинд хүргэж шинэчлэх ажлыг үргэлжүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| | -Стратегийн ач холбогдол бүхий мал аж ахуй, байгалийн болон амьтны гаралтай, нөөцийн хувьд хомс түүхий эд, материалын экспортод хязгаарлалтын бодлого баримталж, зохицуулалт хийх | II улирал | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, Гадаад харилцааны сайд |
| | Оёдлын үйлдвэрийн салбарт захиалгат бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэг-дүүлэхэд дотоодын үндэсний үйлдвэрүүдийн оролцоог өргөжүүлж, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| | -Экспортын үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих эдийн | I улирал | Хөдөө аж ахуй, үйлд- |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | засгийн хөшүүрэг бий болгох | | вэрийн сайд, Гадаад харилцааны сайд |
| | -Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд боловс-руулах үйлдвэрийн эзлэх хувийн жингийн бууралтыг зогсоож, боловсруулах аж үйлдвэрийг сэргээхэд чиглэсэн дэмжлэг үзүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Үндэсний үйлдвэрийг дэмжих, өрсөлдөх чадварыг сайжруулах зорилгоор улсын нөөц, төсвийн байгууллагын хэрэгцээт бүтээг-дэхүүнийг дотоодод суурилагдсан хүч чадлыг ашиглан захиалгаар үйлдвэрлэн хангах талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх, түүнд ил тод, шударга өрсөлдөөний зарчмыг хэрэгжүүлэх | II улирал | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| 11.Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулдаг үйлдвэрүүдийг сэргээх замаар малын гаралтай ноос, ноолуур, арьс ширний таваарлаг чанарыг дээшлүүлэх, малын чанар, угсааг сайжруулах, эрүүлжүүлэх арга хэмжээ авна. | -Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээг-дэхүүний үйлдвэрлэлийг урамшуулах санал боловсруулах | I улирал | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, аймгийн Засаг дарга |
| | -Хот, суурин газрыг сүү, цагаан идээгээр хангах зорилгоор "Цагаан хувьсгал" хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Өндөр ашиг шимтэй малын үзэсгэлэн, үнэ хаялцах худалдааг бүсчлэн зохион байгуулах | II-III улирал | Хөдөө аж ахуй, үйлд-вэрийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | - Засгийн газар хооронд байгуулсан гэрээний дагуу АНУ-аас олгосон тусламжийн улаан буудайн борлуулалтын орлогоос хуримтлагдсан хөрөнгөнөөс хувьчлагдсан мал эмнэлгийн албадыг бэхжүүлэх арга хэмжээ авах | III-IV улирал | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, аймаг ,нийслэлийн Засаг дарга |
| | -Халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, туулгалт, угаалга, оношлогоо шинжилгээнд давхардсан тоогоор 54.7 сая, малын тарилга, лабораторийн шинжилгээнд 21.0 сая толгой малыг хамруулах | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Хүн, малын халдварт /Зооантропоноз/ өвчнөөс малыг эрүүлжүүлэх, малын чанар, угсаа, үржлийн ажлыг сайжруулах | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Бэлчээр ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрийн усан хангамжийг сайжруулахад улсаас дэмжлэг үзүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, аймгийн Засаг дарга |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Бэлчээрийн хортон үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх арга хэмжээг өргөтгөх | II улирал | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| | -Хилийн мал эмнэлгийн хорио цээрийн албыг бэхжүүлэх төсөл боловсруулах | I улирал | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| 12.Хүн амын хүнсний хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилгоор газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | -Газар тариалангийн аж ахуйг сайн чанарын үрээр хангах, үрийн шинэчлэлт хийх зорилгоор элит сортын үржүүлгийн үрийг эрдэм шинжилгээний байгууллага, үр бэлтгэлийн төрөлжсөн компанаар улсын захиалгын дагуу бэлтгүүлэх | III улирал | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, холбогдох аймгийн Засаг дарга |
| | -Газар тариалангийн салбарт техник, тех-нологийн шинэчлэл хийхдээ гадаад зээл, тус-ламжийн хөрөнгийг түлхүү ашиглах чиглэлээр идэвхтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, Гадаад харилцааны сайд |
| | -"Ногоон хувьсгал" хөтөлбөрийг үргэлжлүүлж төмс, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Улаан буудайн улсын нөөцийг жилийн хэрэгцээний 15.0 хувьд, үр тарианы үрийн нөөцийг 20.0 хувьд хүргэх зорилтын хүрээнд буудай сангийн үйл ажиллагааг идэвхжүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| 13.Эдийн засгийн хөгжлийн стратегитай уялдуулан ашигт малтмалын тогтоц, тархацын зүй тогтлыг тодорхойлох, эрдэс түүхий эдийн нөөцийн хэтийн төлөвийг тодотгох зорилгоор геологи, геофизик, геоэкологи, гидро-геологийн судалгааг үргэлжлүүлнэ. | -"Геологийн бүсчилсэн судалгаа" хөтөлбөрийг боловсруулж 1:200000-ны масштабын геологийн зураглалд нутаг дэвсгэрийг хамруулах | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| | -1:50000-ны масштабын зураглалыг тодорхой хэмжээний талбайд явуулж нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархацын зүй тогтол, хэтийн төлөвийн үнэлгээг хийх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| | -Монгол орны геологи, ашигт малтмалын /металлогени/ 1:1000000-ны масштабын зургуудыг зохиож хэвлүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| | -Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгөөр хийж байгаа хайгуул, судалгааны ажлын үр дүн, холбогдох мэдээллийг улсын санд авах журам боловсруулж мөрдүүлэх | I улирал | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Бороогийн алтны бүлэг үндсэн орд, Тосон, Баянголын гольдролын шороон орд, Төмөртийн овооны цайрын орд, Улаанцавын холимог металлын ордууд, Төмөртэйн төмрийн хүдрийн орд, Асгатын мөнгөний орд, Мардай, Хараатын ураны ордууд, Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглах талаар дүгнэлт гаргаж, санал боловсруулан шийдвэрлүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| 14.Худалдаа, үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгон үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, зах зээлийн багтаамжийг өргөтгөх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад анхаарна. | -Худалдааны тухай хууль боловсруулан батлуулж, мөрдүүлэх | I улирал | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, Хууль зүйн сайд |
| | -"Бөөний худалдааны сүлжээ" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд зах зээлийн зарчимд тулгуурласан, бүс нутгийн онцлогт тохирсон бөөний худалдааны сүлжээг хөгжүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, аймгийн Засаг дарга |
| | -Импортын болон дотоодын хүнсний бүтээгдэхүүнд тавих чанар, эрүүл ахуй, ариун цэврийн хяналтыг сайжруулах | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, Эрүүл мэнд,нийгмийн хамгааллын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Аялал жуулчлалыг өргөтгөн хөгжүүлэх зорил-гоор гадаад сурталчилгааг сайжруулах, үйлчил-гээний чанарыг олон улсын жишигт ойртуулах, эрх зүйн үндсийг бүрдүүлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| 15.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүс нутгийг хөгжүүлнэ. | -Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг батлуулж, шийдвэрлүүлэх | I улирал | Дэд бүтцийн хөгжлийн сайд, Сангийн сайд |
| | -Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг хэрэг-жүүлэхэд шаардлагатай эрх зүйн бусад баримт бичгийг боловсруулж шийдвэрлүүлэх | II улирал | Дэд бүтцийн хөгжлийн сайд, Сангийн сайд |
| | -Засгийн газраас Ховд аймгийн Алтайн чанад дахь бүс нутгийг хөгжүүлэх талаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж эхлэх. | оны эхнээс | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Ховд аймгийн Засаг дарга |
| | -Дотоодын түүхий эдийн нөөцийг ашиглан оёмол, сүлжмэл, нэхмэл, арьс шир, үслэг эдлэл, модон эдлэл болон бусад төрлийн бүтээгдэхүүн, хүнсний зүйл үйлдвэрлэх жижиг, дунд үйлд-вэрийг орон нутагт түлхүү хөгжүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -ТАСИС хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрийг | жилдээ | Хөдөө аж ахуй, |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | дэмжих сан байгуулах, сангийн хөрөнгийн 50.0 ба түүнээс дээш хувийг орон нутгийг хөгжүүлэхэд зориулах | | үйлдвэрийн сайд |
| 16.Эдийн засгийн өсөлтийг хангах, үйлдвэрлэл үйлчил-гээг сэргээн хөгжүүлэх бодлогыг дэд бүтцийн хөгж-лоор дэмжих зорилгоор тээвэр, зам харилцааг хөг-жүүлж, техник, технологийн шинэчлэл хийнэ. | -Төмөр замын тээврийг сайжруулах, төмөр замын дагуу 1100 км холбооны шилэн кабелийн технологи нэвтрүүлэх, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, холболтын ажлыг хийж дуусгах | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Иргэний нисэхийн тухай хуулийг хэрэгжүүлж, Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага /ИКАО/-ын CNS/ATM хөтөлборийн хүрээнд агаарын нислэгийн удирдлагыг боловсронгуй болгох, нисэхийн ба нислэгийн аюулгүй байдлыг ИКАО-ийн стандартад хүргэх ажлыг зохион байгуулж эхлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Автотээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, зах зээлийн нөхцөлд дэх автотээврийн хэрэгсэлийн техник ашиглалтын үеэл баримтлалыг боловсруулж хэрэгжүүлэх, нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чанар, баталгааг дээшлүүлэхэд шударга өрсөлдөөнийг өрнүүлэх хөшүүрэг бий болгох | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Далай ашиглах тухай хуулийн хүрээнд далайн тээвэр хийх, их далайн баялгийг ашиглахтай холбогдсон арга хэмжээг авч эхлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Замын-Үүдэд шингэн түлш ачиж, буулгах байгууламж барих болон залуучуудын орон сууц барих зээлийн сан байгуулахад шаардагдах хөрөнгийг олон улсын байгууллага, гадаад орноос үзүүлэх тусламж, тослийн хүрээнд шийдвэрлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд, Сангийн сайд |
| | -Дундговийн Луус-Эрдэнэдалай, Баянгол-Сайхан-Овоо, Ховдын Мянгад-Эрдэнбүрэн, Өвөрхангайн Баянгол-Сант, Дэлгэрхаан- Баян-Өндөр, Товийн Бүрэн-Дэлгэрхаан, Сүхбаатарын Баруун-Урт - Халзан, Хэнтийн Бэрх-Батноров, Архангайн Өндөр- Улаан -Тариатын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөөг барих | Жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Замын санг нэмэгдүүлэх, зарцуулах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, орон нутгийн замын санг бүрэлдүүлэн улс, орон нутгийн чанаргай автозам, замын байгууламжийн засвар арчлалтын ажлыг тогтмолжуулах | Жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Алтанбулаг-Дархан-Улаанбаатар, Дархан-Эрдэнэтийн чиглэлийн хатуу хучилттай замыг барьж ашиглалтад оруулахын зэрэгцээ Налайх-Чойрын чиглэлийн замын барилга угсралтын ажлыг эхлүүлж, Эрдэнэт-Булганы чиглэлийн замыг барих хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Алслагдсан бүс нутгийн зам харилцааг сайжруулах зорилгоор Улаанбаатар-Арвай-хээрийн чиглэлийн замын их засварыг хийх, Арвайхээр-Баянхонгорын чиглэлийн замд хэсэгчилсэн сайжруулалт хийх судалгаа явуулах | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| 17.Харилцаа холбооны салбарт техник, технологийн шинэчлэл хийх ажлыг үргэлжлүүлж үйлчилгээний хүрээг өргөтгөнө | -Цахилгаан холбооны үйлчилгээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах таатай орчныг бүрдүүлж өрсөлдөөн бий болгох | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Багануур, Өндөрхаан, Чойбалсан, Баруун-Урт, Мандалговь, Даланзадгад, Алтай, Улиастай, Улаангом, Ховд, Өлгий, Мөрөн, Цэцэрлэг хотуудын холболтын байгууламж, кабель шугамыг өргөтгөн технологийн шинэчлэл хийх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Өмнөговь, Дундговь аймгийн төв, Тосонцэнгэл сумын холбооны дамжуулах байгууламжийг сансрын холбооны ВиСАТ сүлжээгээр шинэчлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Зарим сум, суурин газрын холбоог орчин үеийн технологиор шинэчлэх төсөл боловсруулж хэрэгжүүлж эхлэх, нарны зайн үүсгүүр үйлдвэрлэж сумдын холбооны салбарыг хангах ажлыг үргэлжлүүлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Хот хоорондын шилэн кабелийн сүлжээ байгуулах төслийг хэрэгжүүлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Шуудангийн сууръ сүлжээ, уламжлалт үйлчилгээний аргад тулгуурлан үйлчилгээний шинэ нэр төрөл нэвтрүүлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| 18.Зах зээлийн харилцаанд зохицуулан барилгын салбарыг сэргээн хөгжүүлнэ. | -Зарим аймгийн төв, суурин газруудын усан хангамж, ариутгах татуургын сүлжээг шинэчилж өргөтгөх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Нийслэлийн захын гэр хорооллыг ундны цэвэр усаар хангах цогц арга хэмжээ авах | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд, Нийслэлийн Засаг дарга |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Барилгын салбарыг сэргээн хөгжүүлэх, орон сууцны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж эхлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Барилгын дулааны алдагдлыг багасгах бодлогын хүрээнд импортоор авдаг дулаан тусгаарлагч дэвшилттэй материалыг дотооддоо үйлдвэрлэх боломжийг судалж, холбогдох төсөл боловсруулах | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Барилгын салбарт материалын үйлдвэрүүдийн үйл ажиллагааг сэргээх, техник, технологийг шинэчлэх, шинээр жижиг, дунд үйлдвэрлэл хөгжүүлэх бодлогын хүрээнд төсөл, арга хэмжээ авч хэрэгжүүлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Байгалийн эрдэс, түүхий эдийг барилгын үйлдвэрлэлд зөв зохистой ашиглах, барилгын дүүргэгч материал элс, хайрга, шохойн боловсруулалтын технологийн түвшинг сайжруулах замаар бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Сум, суурин газрын дулаан хангамжийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг төслийн хүрээнд шийдвэрлэх | жилдээ | Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | ***Г.Хүний нөөцийн хөгжил, нийгмийн хамгааллын бодлого*** | | |
| 19.Хүн амын тогтвортой өсөлтийг хангах, хүний нөөцийн хөгжлийг сайжруулах чиглэл баримтална. | -Хүн амын жилийн дундаж өсөлтийг ойрын ирээдүйд 1.8 хувьд хүргэх зорилтын хүрээнд төрөлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -Хүн ам, орон сууцны 2000 оны ээлжит тооллогыг явуулж, хүн амын тоо, бүтэц, бүрэлдэхүүн болон орон сууцны урьдчилсан дүнг гаргах | I-II улирал | Үндэсний статистикийн газрын дарга, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Хүний хөгжлийн чиглэлээр Засгийн газрын гүйцэтгэх зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад гэрээний дагуу хариуцуулах санал боловсруулан шийдвэрлүүлэх | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүйн сайд |
| 20.Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурал, ажилгүйдлийг багасгах, эмзэг хэсгийн нийгмийн хамгааллыг сайжруулах замаар иргэдийн амьжиргааны баталгааг хангана. | -Ядуурлыг бууруулах, ажлын байр бий болгох,жижиг дунд үйлдвэрийг дэмжихэд чиглэгдсэн дотоод, гадаадын хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийн сан бий болгох | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлэх боломжтой тахир дутуу болон одой иргэдийг хөдөлмөрийн захаар дамжуулан ажлын байраар хангах арга хэмжээ авах | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -Хөдөлмөрийн зах зээлийн талаархи төрийн бодлогын үзэл баримтлалыг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх | III улирал | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -ЕБС-ийн 8,10 дугаар анги төгсөөд ажил, сургуульгүй үлдсэн охид, хөвгүүдийн 20 ба түүнээс дээш хувьд нь мэргэжил эзэмшүүлэх, мэргэжлийн баримжаа олгох ажлыг зохион байгуулах | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -Хөдөлмөр зохицуулалтын албадын үйл ажиллагааг боловсронгуй болгох, эрх зүйн орчинг төлөвшүүлэх, удирдах боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэдээллийн сүлжээг сайжруулах арга хэмжээ авах | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -Хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэхэд чиглэсэн холбогдох арга хэмжээ авах | I улирал | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -Албан бус салбарт ажиллагчдын хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлтийн байдлыг судлан тодорхойлох, тэдний эрх ашгийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, мэдээлэлд хамруулах | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн байгууллага, түүний нэгжийн удирдлагын тогтолцоог нутаг дэвсгэрийн түвшинд оновчтой тогтоох, хөдөлмөр эрхлэлтийн ба хяналтын албадын үйл ажиллагааг сайжруулах | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -Төрийн албан хаагчдын цалин хөлсийг амьжиргааны өртгийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэх арга хэмжээ авах | I улирал | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -Тэтгэврийн даатгалд иргэдийг хамруулах сонирхлыг нэмэгдүүлэх, хүрээг өргөтгөх, хагас хуримтлалын журамд шилжүүлэх ажлыг нэрийн данс нээх, эхний үлдэгдлийг тооцох, шимтгэлийг дансанд хуримтлуулахаас эхлэх | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -Нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулж эхлэх | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг төрийн бус байгууллага болон буяны байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх ажлыг турших | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн | III улирал | Эрүүл мэнд, нийгмийн |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | | | хамгаалалын сайд |
| | шугамаар ажлын байр бий болгох, жижиг зээлийн төслийн тоог нэмэгдүүлэхэд түлхүү анхаарах | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| 21.Хүн амыг өвчин, эмгэгээс сэргийлэх ажлыг өргөжүүлж, ядуучуудад үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлнэ. | -Эрүүл мэндийн төрөлжсөн төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнг бодиттой дээшлүүлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авах | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайд |
| | -"Эрүүл мэндийн салбарын хөгжил" хөтөл-бөрийн хүрээнд Дорноговь, Ховд аймгийн төв, нийслэлийн Сүхбаатар дүүрэгт байгуулсан өрхийн эмнэлгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, нийслэлийн Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт шинээр байгуулж, эмч, сувилагчдыг давтан сургах, санхүүжилтийн шинэ журмыг туршин нэвтрүүлэх | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайд |
| | -Хөдөөгийн хүн амд эмнэлгийн тусламж, үйлчилгээг жигд, хүртээмжтэй үзүүлэх чиглэлээр бүсийн эмчилгээ оношлогооны төвүүд байгуулах, улмаар лавлагаат тусламжийн үйлчилгээг нэвтрүүлж эхлэх | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайд |
| | -Насанд хүрэгчдийн өвчлөл, нас баралтын голлох шалтгаан болсон зүрх судас, амьсгал, хоол боловсруулах эрхтний өвчнүүд болон хорт хавдар, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар дорвитой арга хэмжээ авах | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайд |
| | -Өрхийн эмнэлэгт үйлчлүүлэгч-эмзэг бүлгийн иргэдийн зардлын нормыг ердийн бүлгийнхээс илүү тогтоож мөрдүүлэх | II улирал | Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайд, Сангийн сайд |
| | -Хөдөөгийн сум, багийг эмнэлгийн мэргэжилт-нээр жигд хангах, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, урамшууллын хөшүүрэг бий болгох арга хэмжээ авах | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайд, Аймаг, сум, багийн Засаг дарга |
| | -Эмч, эмнэлгийн ажилтан, мэргэжилтний цалин хөлсийг бүс нутгийн ялгаа, мэргэжлийн ур чадвар, ажлын бодит үр дүн, тогтвор суурьшил зэргийг харгалзан тогтоон олгох журмыг турших | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайд, Сангийн сайд |
| | -Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, тоног төхөөрөмжийн тооллого явуулж, дахин үнэлгээ | III улирал | Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайд, |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | хийх, элэгдэл байгуулах, санхүүжилтийн шинэ чиглэлийг судалж боловсруулах | | Сангийн сайд |
| | -Магадлан итгэмжлэгдсэн хувийн эмнэлэгт эрүүл мэндийн даатгалтай иргэн эмчлүүлсэн тохиолдолд эмчилгээний зардлыг даатгалын сангаас төлөх эдийн засгийн хөшүүргийг нэвтрүүлэх | II улирал | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд |
| 22.Биеийн тамир, спортыг хүн амын эрүүл аж төрөх ёсны хэрэглүүр болгон хөгжүүлэхэд анхаарна. | -"Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх" хөтөлбөрийг хэрэгжүүлэх | жилдээ | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -Биеийн тамир, спортын тухай хуулийг батлуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | II улирал | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| | -Сиднейн олимпид оролцох эрх авсан баг, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх нөхцөлийг хангаж, олимпийн тоглолтод зохион байгуулалттай оролцуулах | I-III улирал | Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд |
| 23. Боловсрол, шинжлэх ухаан, технологи, соёл, урлагийн салбарын шинэчлэлийг эрчимжүүлж, гэгээрлийн байгууллагын оновчтой бүтэц бүрдүүлнэ. | -Боловсролын шинэчлэлийн дунд хугацааны /2001-2005/ стратегийн хөтөлбөрийг боловсруулан хөрөнгө оруулалтын чиглэлийг тодорхойлох | жилдээ | Гэгээрлийн сайд, Сангийн сайд |
| | -Боловсролын хуульд заасны дагуу ЕБС-ийн дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нормативт зардалд тусган санхүүжүүлэх | оны эхнээс | Сангийн сайд, Гэгээрлийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Ерөнхий боловсролын сургуулийн 8 дугаар анги төгсөгчдийн 75 хувийг 9 дүгээр ангид, 25 хувийг мэргэжлийн анхан шатны сургуульд элсүүлэн сургах | II-III улирал | Гэгээрлийн сайд |
| | -Бүх шатны сургууль, цэцэрлэгийн удирдах зөвлөлийг бүрэн байгуулж, багш нарын зөвлөл, заах аргын нэгдлийг шинэ шаардлагаар ажиллуулах, дотоод зохион байгуулалтыг шинэчлэх | жилдээ | Гэгээрлийн сайд |
| | -Хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсрол нөхөн олгох, иргэдийн амьдрах чадварыг дээшлүүлэхэд чиглүүлэн албан бус боловсролын орон нутгийн тогтолцоог төлөвшүүлэх | жилдээ | Гэгээрлийн сайд |
| | -Ерөнхий боловсролын сургуулийн бүтцийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх бод-лого, чиглэлийг боловсруулах, сургуулийн өмнөх боловсролын агуулгыг шинэчлэх түүнийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах | жилдээ | Гэгээрлийн сайд |
| | -Багш, боловсрол, соёл урлагийн удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх тогтолцооны шинэчлэлийг гүнзгийрүүлэн хамрах хүрээ, зарцуулах хөрөнгийн | жилдээ | Гэгээрлийн сайд |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | хэмжээг нэмэгдүүлж, төвлөрлийг багасгах, тэдний оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах | | |
| | -Дээд боловсролын болон мэргэжлийн сургууль-лиудын бие даасан байдлыг нэмэгдүүлэхийн тэрэгцээ сургалтын агуулга стандартыг тогтоох, багшлах боловсон хүчний мэргэжлийн түвшинд тавих шаардлагыг нэмэгдүүлэх | жилдээ | Гэгээрлийн сайд |
| | -Техникийн болон мэргэжлийн боловсролын стандартын загварыг боловсруулан эхний ээлжинд түгээмэл мэргэжлийн /агуулгын, үнэлгээний, орчны/ стандарт, арга зүйг боловсруулан турших | II-III улирал | Гэгээрлийн сайд |
| | -Хөдөөгийн алслагдсан сумдын сургуулийг багшаар хангах, тогтвор суурьшилтай ажиллуулахад онцгой анхаарч тэднийг урамшуулах хөшүүргийг бий болгох | жилдээ | Гэгээрлийн сайд, аймаг, сум, багийн Засаг дарга |
| | -Сургуулиудын мэдээллийн сүлжээг өргөжүүлэх, номын сангийн үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах | жилдээ | Гэгээрлийн сайд, аймаг, сум, багийн Засаг дарга |
| | -Шинжлэх ухаан, технологийн төсөл, арга хэм-жээнд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх | жилдээ | Гэгээрлийн сайд, Сангийн сайд |
| | -Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн сан баяжуулах, мэдээллийн нэгдсэн сүлжээг өргө-жүүлэх, үйлчилгээ, хүртээмжийг нь нэмэгдүүлэх | жилдээ | Гэгээрлийн сайд |
| | -Шинжлэх ухаан, технологийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, гадаад орнуудтай харилцах хоёр болон олон талын гэрээ хэлэлцээрийг шинэчлэн байгуулах | жилдээ | Гэгээрлийн сайд |
| | -Боловсрол-шинжлэх ухаан-бизнесийн байгуул-лагын үр ашигтай хамтын ажиллагааг урамшуулах эрх зүйн болон эдийн засгийн орчин бүрдүүлэх | жилдээ | Гэгээрлийн сайд, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайд |
| | -Мартагдаж үгүй болох аюулд хүрсэн ардын язгуур урлаг, өв соёлыг сэргээх, өвлүүлэн үлдээхэд чиглэсэн арга хэмжээ авах, түүх соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах ажлыг үргэлжлүүлэх | жилдээ | Гэгээрлийн сайд |
| | -Уран бүтээлийн ажлын чанар, уран сайхны түвшинг харгалзан санхүүжүүлэх хөшүүргийг боловсронгуй болгох, соёл, урлагийн байгуул-лагын бүтэц, удирдлагын оновчтой түвшинг тогтооход чиглэсэн бүтцийн өөрчлөлт хийх | жилдээ | Гэгээрлийн сайд, Сангийн сайд, аймаг нийслэлийн Засаг дарга |
| | -Монгол Улсын соёл, урлагийг гадаадад өргөн | жилдээ | Гэгээрлийн сайд, |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | сурталчлах, соёлын салбарын гадаад харилцааг өргөжүүлэх | | Гадаад харилцааны сайд |
| | ***Д.Эрхзүйн шинэчлэл, аюулгүй байдал, хамтын ажиллагааны чиглэл*** | | |
| 24.Шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүгчийн ёс зүй болон сахилга, хариуц-лагыг дээшлүүлэх, хууль зүйн албаны тогтолцоог боловс-ронгуй болгох чиглэлээр эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлнэ. | -Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт тусгагдсан хууль тогтоомжийг тэргүүн ээлжинд батлуулан мөрдүүлэх | жилдээ | Хуульзүйн сайд |
| | -Хүн амд үзүүлэх эрх зүйн үйлчилгээ шуурхай, хүртээлтэй байх зохион байгуулалтын нэмэлт арга хэмжээ авах | жилдээ | Хууль зүйн сайд |
| | -Хуульчдыг сонгон шалгаруулах, давтан сургах, мэргэжлийг дээшлүүлэх тогтолцоог шинэчлэн тогтоох | жилдээ | Хууль зүйн сайд |
| | -Хууль зүйн албаны тогтолцоог шинэчлэн өөрчлөх санал боловсруулах | II улирал | Хууль зүйн сайд |
| | -Хууль зүйн мэргэжлийн сургуулийг багшлах боловсон хүчин, эрдэм шинжилгээний ажилтнаар хангах, материаллаг баазыг бэхжүүлэх төслийг судлан хэрэгжүүлэх | жилдээ | Хууль зүйн сайд, Гэгээрлийн сайд |
| | -Шүүгчийн хараат бус байдлыг хангах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж, тэдний нийгмийн баталгааг хангах ажлыг сайжруулах | жилдээ | Хууль зүйн сайд, Дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл |
| | -Шүүхийн ажлын дотоод зохион байгуулалтыг боловсронгуй болгох, шүүхэд орчин үеийн техник хэрэгсэл нэвтрүүлэх замаар шүүгчийн ажлын нөхцөлийг сайжруулах, тэднийг чадваржуулах ажлыг зохион байгуулах | жилдээ | Хууль зүйн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөл |
| | -Шүүгчийн ёс зүйн ба сахилга, хариуцлагын байдалд дүгнэлт гарган мэдээлж байх тогтолцоо, эрх зүйн үндсийг бүрдүүлэх | II улирал | Хууль зүйн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөл |
| | -Цагдаагийн байгууллагын автомашины паркийг шинэчлэх, мэдээллийн сүлжээг өргөжүүлэх ажлыг эхлүүлэх | жилдээ | Хууль зүйн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспортыг шинэ загвараар солих ажлыг эхлүүлэх | I улирлаас | Хууль зүйн сайд |
| | -Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн цахим тооцоолуурын нэгдсэн сүлжээ байгуулах төслийг эхлүүлэх | III улирал | Хууль зүйн сайд |
| 25.Төрөөс экологийн талаар баримтлах бодлогыг хэрэг-жүүлэх, | -Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион | жилдээ | Байгаль орчны сайд |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| байгаль орчныг хамгаалах удирдлага, зохион байгуулалт, хяналтын тогтолцоог бэхжүүлнэ. | байгуулах, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа явуулах ажлыг эрчимжүүлэх | | |
| | -Газрын тухай болон Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, бэлчээрийг зохистой ашиглах, даацыг тэнцвэржүүлэх, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах эрх зүйн орчин бүрдүүлэх | жилдээ | Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд, Байгаль орчны сайд |
| | -Агаар бохирдуулах бодисын стандарт, зөвшөөрөгдөх дээд хэмжээ тогтоож, түүнд хяналт тавих | жилдээ | Байгаль орчны сайд |
| | -Цөлжилт, хээршилт явагдаж байгаа бүс нутагт мод тарих, ойг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх | жилдээ | Байгаль орчны сайд |
| | -Химийн хорт бодисын хадгалалт, хамгаалалт, ашиглалтын байдалд улсын үзлэг явуулах, нэгдсэн үнэлгээ өгөх | жилдээ | Байгаль орчны сайд |
| | -Зарим нутгийн усны нөөц, чанарыг судлах, ус ашиглалтын тоо бүртгэлийг явуулах, хатуулаг, эрдэсжилт ихтэй усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх арга хэмжээ авах | жилдээ | Байгаль орчны сайд |
| | -Хог хаягдлыг бууруулах, ашиглалтыг сайжруулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх | II улирал | Байгаль орчны сайд |
| | -Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэн хамгаалалтын захиргаадыг бэхжүүлэх | жилдээ | Байгаль орчны сайд |
| | -Байгалийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг өргөжүүлэх | жилдээ | Байгаль орчны сайд |
| | -Ус цаг уур, орчны шинжилгээний техник, технологийн шинэчлэлтийг хийх, уур амьсгалын өөрчлөлтийн хандлага, эерэг сөрөг нөлөөллийг тогтоох | жилдээ | Байгаль орчны сайд |
| | -Үйлдвэрлэлийн зориулалтаар ашигладаг зарим амьтан, ургамлын тархац, нөөцийг шинэчлэн тогтоох | жилдээ | Байгаль орчны сайд |
| | -Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, сурталчлах, мэдээлэх ажлыг сайжруулах | жилдээ | Байгаль орчны сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга |
| | -Ойн хөнөөлт шавьж, хортон мэрэгчидтэй тэмцэх арга хэмжээг зохион байгуулах | жилдээ | Байгаль орчны сайд |
| 26.Төрийн батлан хамгаалах бодлогын хэрэгжилт, цэр-гийн байгууламтыг шинэч-лэх үйл ажиллагаар эрчим-жүүлэн улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг дээшлүүлнэ. | -Батлан хамгаалах хууль тогтоомж, цэргийн шинэчлэлийн бодлогын хэрэгжилтийг эрчим-жүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах | жилдээ | Батлан хамгаалахын сайд |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | -Зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай болгон өөрчлөх үйл ажиллагаар бүх шатанд эр-чимжүүлэх, дайчилгааны бэлтгэл нөөцийг нутаг дэвсгэрийн зарчмаар бэлтгэх тогтолцоог бүр-дүүлэх, цэргийн зэвсэглэл, техникийн зарим хэсгийг шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх | жилдээ | Батлан хамгаалахын сайд |
| | -Улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах, хилийн анги, салбаруудын зэвсэглэл, техник хэрэгсэл, ахуй хангалтыг сайжруулах, ул-сын хил дээр алба хаагчдын нийгмийн хангамжийг дээшлүүлэх ажлыг ээлж дараатай шийдвэрлэх | жилдээ | Батлан хамгаалахын сайд |
| | -Гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, аврах, хор уршгийг арилгах арга хэмжээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, байгалийн гам-шигтай тэмцэх орон нутгийн хүч хэрэгслийг бэхжүүлэх, цэргийн анги салбар, тусгай мэргэж-лийн байгууллагуудын иргэний хамгаалалтын хамтарсан ажиллагаар хэвшүүлэх | жилдээ | Батлан хамгаалахын сайд |
| | -Батлан хамгаалах салбарын гадаад харилцаг өргөжүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх олон улсын хүч чармайлт, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох | жилдээ | Батлан хамгаалахын сайд |
| 27.Гадаад харилцааг өргө-жүүлж, улсын аюулгүй бай-дал, үндэсний хөгжилд олон улсын таатай гадаад орчин бүрдүүлэхийг эрхэмлэнэ. | -ОХУ, БНХАУ болон АНУ, Япон зэрэг орнуудтай тогтоосон харилцаа тэргүүлэх ач холбогдолтойд үзэж, олон улсын болон бүс нутгийн харилцааны хөгжил, өрнөлттэй уялдуулан хөгжүүлэх. | жилдээ | Гадаад харилцааны сайд |
| | -Ази, Номхон далайн бүс нутаг, Европ, Төв Азийн орнуудтай харилцан ойлголцлыг бэхжүүлэх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх | жилдээ | Гадаад харилцааны сайд |
| | -Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдал, эдийн засгийн олон талт хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулж, АСЕАН-ы Бүсийн Чуулганы үйл ажиллагаанд идэвхтэй оролцох | жилдээ | Гадаад харилцааны сайд |
| | -НҮБ болон олон улсын бусад байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, хүч бололцоог нь үр бүтээлтэй ашиглах | жилдээ | Гадаад харилцааны сайд |
| | -Хилийн чанадад иргэдийнхээ эрх, ашгийг хамгаалах эрх зүйн үндсийг сайжруулж, иргэд зорчих явдлыг илүү | жилдээ | Гадаад харилцааны сайд |

| 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|
| | чөлөөтэй болгох | | |
| | -Хандивлагчдын амласан хөрөнгийг тохиролц-соны дагуу хугацаанд нь бүрэн авч хэрэгжүүлэх, гадаадын зээл тусламжийн зохицуулалт, удирд-лага, эрх зүйн орчинг сайжруулах, гадаадын зээл тусламжийг зохицуулах хууль боловсруулж батлуулах | жилдээ | Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, холбогдох бусад сайд |
| | -Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эрх зүйн болон эдийн засгийн таатай нөхцөл бүрдүү-лэх, гадаадын хөрөнгө оруулалтыг тэргүүлэх сал-бруудад оруулах, тэргүүлэх салбарын төслүүдийг гадаадын хөрөнгө оруулагчдад сурталчлах | жилдээ | Гадаад харилцааны сайд |
| | -Хөгжиж байгаа орнуудын гадаад өрийг хүчингүй болгох, хөнгөвчлөх чиглэлээр олон улсын хэмжээнд зохиогдож байгаа арга хэмжээг судлах, түүнд Монгол Улсыг татан оролцуулах замаар гадаад өрийг цайруулах талаар санал боловсруулах | жилдээ | Гадаад харилцааны сайд |
| 28.ДХБ-ын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж шинэ хэлэл-цээрүүдэд идэвхтэй оролцох, монголын бараа бүтээг-дэхүүн гадаадын зах зээлд гарах таатай нөхцөлийг ДХБ-ын тогтолцооны хүрээнд бүрдүүлэх, мэдээллийн технологид тулгуурласан худалдаа нэвтрүүлэх талаар ажиллана. | -ДХБ-д гаргаж өгдөг мэдээ, мэдээллийг хугацаанд нь тогтмол өгч байх | тухай бүр | Гадаад харилцааны сайд |
| | -Дэлхийн худалдааны байгууллагад БНХАУ, ОХУ болон ТУХН-ийн орнууд элсэхтэй холбогдуулан эдгээр оронтой тарифын хэлэлцээр хийх ажлыг үргэлжлүүлэх | жилдээ | Гадаад харилцааны сайд, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд |
| | -Гадаад худалдааны балансын тоо, мэдээллийг олон улсын стандарт арга зүйд нийцсэн нэгдсэн нэг аргачлалаар гаргаж байх арга хэмжээ авах | жилдээ | Гадаад харилцааны сайд, Үндэсний статистикийн газрын дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч |
| | -ОХУ-тай худалдааг либеральчлах хэлэлцээ хийх | жилдээ | Гадаад харилцааны сайд |
| | -АНУ-ын хөнгөлөлтийн Ерөнхий системд /GSP/ хамаарагдах арга хэмжээ авах | жилдээ | Гадаад харилцааны сайд |
| | -"Бангконгийн хэлэлцээр"-т нэгдэн орох асуудлыг судалж шийдэх | жилдээ | Гадаад харилцааны сайд |
| | -Мэдээллийн технологид тулгуурласан худалдаа нэвтрүүлэх асуудлыг судлах | жилдээ | Гадаад харилцааны сайд |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2000 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр** **Дугаар 03** **Улаанбаатар хот**

**Төрөөс мөнгөний бодлогын талаар 2000 онд баримтлах чиглэл батлах тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2000 онд баримтлах чиглэлийг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газартай хамтран зохион байгуулж, дүнг улирал тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанк /Ж.Үнэнбат/-д даалгасугай.

**ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ**

*Монгол Улсын Их Хурлын 2000 оны 03 дугаар тогтоолын хавсралт*

## ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2000 ОНД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛ

Төрөөс 2000 онд баримтлах мөнгөний бодлого нь мөнгөний нийлүүлэлтийг оновчтой зохицуулж, төгрөгийн тогтвортой байдлыг хангахад чиглэнэ. Энэ хүрээнд үндэсний эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, санхүү банкны салбарыг тогтворжуулах, банкны бүтцийн өөрчлөлтийг өргөжүүлэн гүнзгийрүүлэх зорилгоор бодлогын чанартай дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

### Нэг. Мөнгөний бодлогын талаар

Мөнгөний нийлүүлэлтийг зохистой удирдах замаар санхүүгийн жилийн инфляцийн түвшинг 15 хувиас хэтрүүлэхгүй байлгаж төгрөгийн харьцангуй тогтвортой байдлыг хангана. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг 20 хувиас хэтрүүлэхгүй ба үнийн өөрчлөлттэй уялдуулан хүүгийн түвшинг бууруулах замаар бодит эдийн засгийн өсөн тэлэх боломжийг бүрдүүлэх чиглэл баримтална.

Мөнгөний бодлогын хэрэгслүүдийн хоорондын уялдааг нягтруулан, түр зуурын шинжтэй эрэлт болон нийлүүлэлтээс үүдэлтэй огцом хүндрэлийг даван туулахад бодлогын хэрэгслүүдийг үр дүнтэй хослуулан мөнгөний бодлогыг нээлттэй хэрэгжүүлэхэд анхаарна. Заавал байлгах нөөцийн шаардлагыг бууруулахын зэрэгцээ, түүнийг зөрчиж байгаа банкуудын зээлийн өрийн үлдэгдэлд хязгаар тогтоох ажиллагааг үргэлжлүүлнэ.

Монголбанкнаас Засгийн газарт үзүүлэх банкны үйлчилгээг гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ. Засгийн газар, Монголбанкны мэдээлэл солилцоог сайжруулж, мөнгөний болон төсвийн бодлогын уялдааг дээшлүүлнэ.

Засгийн газар, Монголбанкны хооронд үүссэн өглөг, авлагын зарим асуудлыг Улсын Их Хуралд танилцуулан шийдвэрлэнэ.

Засгийн газрын бондыг нийтэд чөлөөтэй арилжаалах нөхцөлийг бүрдүүлэх, түүний зах зээлийг бий болгож хөгжүүлэх арга хэмжээг Засгийн газар, Монголбанк хамтран зохион байгуулна.

Макроэдийн засгийн тэнцвэрийг алдагдуулах эрс өөрчлөлт гарснаас бусад нөхцөлд төгрөгийн гадаад валютаар илэрхийлэгдэх ханшны тогтолцоонд Монголбанкнаас оролцохыг хязгаарлах бөгөөд гадаад худалдаа, төлбөрийн тэнцлийн байдалд уян хатан зохицсон байх зарчмыг баримтална. Монгол Улсын гадаад валютын цэвэр нөөцийг оны эцсийн байдлаар 95 сая ам.долларт хүргэнэ.

### Хоёр. Санхүүгийн салбарыг эрүүлжүүлэх, банкны бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх талаар

Банкны эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэн банкны системийн төвлөрлийг бий болгох, банкны тухай хууль тогтоомжид заасан зохистой харьцааны үзүүлэлтийг хангуулах замаар санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг сайжруулна. Банкны бус санхүүгийн байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нягтлан бодох бүртгэлийн үндсийг тавих, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх судалгаа явуулах, банкны зээлээс бусад хэлбэрийн зуучлалын арга хэлбэрийг нэвтрүүлэх замаар санхүүгийн зуучлалын хүрээг өргөжүүлнэ.

Банкны тухай хуулийн дагуу банкинд бүтцийн өөрчлөлт хийхтэй уялдуулан банкийг өөрчлөн байгуулах /нэгтгэх, нийлүүлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/ зарчмыг тогтоож мөрдүүлнэ.

Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтийг биелүүлээгүйгээс үйл ажиллагаа нь доройтож, санхүү төлбөрийн чадварын байдал нь хүндрэлд орсон банкинд хариуцлага хүлээлгэх, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагааг үргэлжлүүлнэ. Банкны

салбарын хүндрэлийн анхдагч эх сурвалж болсон чанаргүй зээлийг төлүүлэх, албадах чиглэлээр арилжааны банкууд, Монголбанк, Засгийн газар, хууль хяналтын байгууллагатай хамтран нягт ажиллана.

Бүтцийн өөрчлөлтийн хүрээнд Хөдөө аж ахуйн банкийг хувьчлах, хувьчлагдах хүртэл хугацаанд төр мэдэлдээ байлган үйл ажиллагаа нь хэвийн явуулах зорилгоор Засгийн газар, Монголбанкнаас дахин хөрөнгөжүүлэх арга хэмжээ авна. Хөдөө аж ахуйн банкны зардлыг цаашид хямдруулах, үр ашигтай бүтцийн тогтолцоо бий болгох зорилгоор банкийг жижигрүүлэн өөрчлөн зохион байгуулах бодлого баримтална. Тэтгэвэр, тэтгэмж олгох үйлчилгээг Хөдөө аж ахуйн банк болон бусад байгууллагаар дамжуулан Засгийн газраас нөхөн төлбөртэй явуулна.

Хадгаламжийн банкийг бие даасан үйл ажиллагаатай санхүүгийн зуучлагч болгох арга замыг судална.

Банкуудын дотоод хяналтын тогтолцоог хэвшүүлж, олон улсын практикт нийцсэн нягтлан бодох бүртгэлийн программаар үйл ажиллагаа нь автоматжуулна. Банкны үйлчилгээг олон нийтэд шуурхай хүргэх чиглэлээр орон нутаг дахь банкуудын бүтэц, зохион байгуулалт, байршлыг оновчтой болгох арга хэмжээ авна.

Санхүүгийн секторыг хөгжүүлэх зорилгоор банк бус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг тогтвортой, үр ашигтай явуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, нягтлан бодох бүртгэлийн журмыг шинээр боловсруулж, тэдгээрийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавина.

Санхүү банкны системийг эрүүлжүүлж, хөгжлийг нь түргэсгэхэд чиглэгдсэн арга хэмжээг олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламжтайгаар хэрэгжүүлэн, тэдгээртэй хамтран дунд болон урт хугацааны хамтын ажиллагааны арга хэлбэрийг тодорхойлно.

Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа, программ хангамжийг боловсронгуй болгох чиглэлээр мөрдөж байгаа эрх зүйн баримтыг боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангана.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2000 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр** **Дугаар 04** **Улаанбаатар хот**

### Монгол Улсын 1998 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын 1998 оны төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийн орлогыг **189.934.590.4** мянган төгрөгөөр, зарлагыг **286.238.654.6** мянган төгрөгөөр баталсугай.

**ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

**2000 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр** **Дугаар 05** **Улаанбаатар хот**

### Парламентын музейг үндэслэн байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Үндэсний түүхийн музейн харьяанд Парламентын музей байгуулах ажлыг эхлүүлсүгэй.

2.Парламентын музей байгуулах, цаашдын үйл ажиллагааных нь зардлыг жил бүрийн улсын төвлөрсөн төсөвт тусган батлуулж байхыг Засгийн газар /Р.Амаржаргал/-т даалгасугай.

3.Парламентын музей байгуулах бэлтгэл ажлыг холбогдох байгууллагаас хийж гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхийг Төрийн байгуулалтын байнгын хороо /Д.Энхтайван/, Улсын Их Хурлын Тамгын газар /Б.Энэбиш/-т даалгасугай.

**ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**1999 оны 12 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 214** **Улаанбаатар хот**

### Зарим хүнд Монгол Улсын гавьяат цол хүртээх тухай

Үйлдвэр, барилга, геологи, мал аж ахуй, аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, ажлын байр шинээр бий болгох, бүтээгдэхүүний чанар, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, хэрэглэгчдийн хэрэгцээг найдвартай хангахад чухал хувь нэмэр оруулж байгааг нь үнэлж дор дурдсан хүмүүст Монгол Улсын гавьяат цол хүртээсүгэй.

**Монгол Улсын гавьяат уурхайчин цолоор:**

Хоохоны Мягмар – Дархан -Уул аймгийн "Шарын гол" хувьцаат компанийн авто хүнд-механизмын хэсгийн жолооч

**Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолоор:**

Лхагвын Мөнхтогоо – Нийслэлийн алт хайгуул, олборлолтын "Монгол алт" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн геологич

**Монгол Улсын гавьяат барилгачин цолоор:**

Ловонгийн Төмөрбаатар - Өвөрхангай аймгийн барилга, үйлдвэрлэл, үйлчилгээний "Ган нэгдэл" хувьцаат компанийн ерөнхий захирал

**Монгол Улсын худалдааны гавьяат ажилтан цолоор:**

Амарбаярын Шагдарсүрэн – Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны "Номин трейд" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн ерөнхий менежер

**Монгол Улсын гавьяат зоотехникч цолоор:**

Лувсанбалдангийн Лхаасүрэн – Завхан аймгийн Хөдөө аж ахуйн газрын мал аж ахуйн үржлийн албаны дарга бөгөөд ерөнхий мал зүйч

**Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цолоор:**

Бэгзсүрэнгийн Дэлгэрсүрэн – Нийслэлийн гадаадын аялал жуулчлалын "Жуулчин" хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**1999 оны 12 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 215** **Улаанбаатар хот**

### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэр, барилга, геологи, автозам, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлал, боловсрол, эрүүл мэнд, урлагийн салбар болон төр захиргааны байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Цэдэндамбаагийн Балдандорж – Шинжлэх ухааны академийн харьяа Геоэкологийн хүрээлэнгийн усны нөөц, ус ашиглалтын салбарын эрхлэгч

2. Чимэд – Очирын Ганзүг – Нийслэлийн "Батсуурь" ХЭАА-н эзэн

3. Хайдарын Далелхан – Нийслэлийн "Моншандас" ХХК-ийн ерөнхий геологич

4. Лувсанцэрэнгийн Дүвжир – Төвийн бүсийн эдийн засгийн нарийн бичгийн дарга

5. Гомбожавын Ноймор – Говь-Алтай аймгийн ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын хөгжимчин

6. Дагестаны Рауяат – Говьсүмбэр аймгийн "Говь гео" ХК-ийн Налгарын уурхайн тэсэлгээчин

7. Дамбийн Санжаадорж – Нийслэлийн "Эрэл" ХХК-ийн ахлах геологич

8. Батдоржийн Цэрэндорж – Дорнод аймгийн Чойбалсан сумын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн "Баянталбай" ХК-ийн гүйцэтгэх захирал

9. Сономын Чогсомжав - Нийслэлийн Дулааны шугам сүлжээний газрын ахлах инженер

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Галсанбалжирын Адъяа – Говь-Алтай аймгийн "Нутгийн зам" ХК-ийн ажилчин

2. Ширбазарын Баасандорж – Улсын геологийн судалгааны товчооны захирал

3. Дамдиндоржийн Баатар – Булган

аймгийн Тэшиг сум дахь Монгол –Оросын хамтарсан "Эм энд Даймонд" ХК-ийн ерөнхий захирал

4. Лувсанжамцын Базарсад – Дархан-Уул аймгийн "Монгол алт" ХК-ийн ахлах геологич

5. Сүхбаатарын Батболд – Нийслэлийн "Алтай трейдинг" ХХК-ийн ерөнхий захирал

6. Баатарын Батмөнх – Нийслэлийн "Гэгээ" компани /УҮГ/-ийн аж ахуйн дарга

7. Баттогтохын Батсүрэн – Төв аймгийн Зуунмод сумын "Номт" хоршооны эзэн

8. Дашийн Батцагаан – Говь-Алтай аймгийн ерөнхий архитекторч бөгөөд барилга, хот байгуулалтын албаны дарга

9. Надмидын Баяртсайхан – Монгол Улсын Их Хурлын гишүүн

10. Базарын Болдбаатар – Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын ахлах референт

11. Чийвийхүүгийн Ганбаатар - Өвөрхангай аймаг дахь баруун чиглэлийн зам барилгын трестийн ажилчин

12. Борхүүгийн Ганхуяг – Дорноговь аймгийн Сайншанд сумын "Гантулга трейд" ХХК-ийн захирал

13. Цэрэнгийн Гочоо – Дорноговь аймгийн Алтанширээ сумын "Шинэ саруул зам" хоршооны дарга

14. Галзангийн Даваасамбуу - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын ахлах референт

15. Жадамбын Даваасүрэн – Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Хөвсгөл геологи" ХК-ийн Урт сайрын алтны уурхайн орлогч дарга, ерөнхий геологич

16. Мижидийн Дамдинсүрэн – Нийслэлийн "АПУ" ХК-ийн цахилгааны инженер

17. Долгорын Дашцэрэн – Ашигт малтмалын Хэрэг эрхлэх газрын харьяа геологийн мэдээллийн төвийн геологич

18. Раднаагийн Должинсүрэн – Нийслэлийн "Морьтон Монгол" ХК-ийн дэд захирал

19. Банзрагчийн Доржхорлоо - Өвөрхангай аймгийн Богд сумын "Буман-Янгир" ХХК-ийн захирал

20. Цээпилийн Дунгаа – Нийслэлийн "АПУ" ХК-ийн инженер-технологич

21. Баатархүүгийн Дүүдээ – Говь-Алтай аймгийн Цогт сумын хүн эмнэлгийн салбарын эрхлэгч

22. Батын Дэнсмаа – Нийслэлийн "Атар-Өргөө" ХХК-ийн ажилчин

23. Даваадоржийн Жаргал - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын "Дэлгэрэх" ХК-ийн ерөнхий захирал

24. Бат-Очирын Жүгдэр – Орхон аймгийн Баян-Өндөр сумын 7 дугаар сургуулийн математикийн багш

25. Сэнгээгийн Лувсандаш – Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Хөвсгөл" ХК-ийн гүйцэтгэх захирал

26. Лүүрэвийн Лхагвасүрэн – Дорнод аймгийн Баяндун сум дахь алтны хайгуул, олборлолтын "Дун-Эрдэнэ" ХХК-ийн ерөнхий захирал

27. Лхамхүүгийн Лхасүрэн – Нийслэлийн "Атар-Өргөө" ХК-ийн маркетингийн албаны дарга

28. Шаравсамбуугийн Лхүндэв – Нийслэлийн "Гурван талст" ХК-ийн захирал

29. Мягмарын Мижид – Нийслэлийн "Атар-Өргөө" ХК-ийн ажилчин

30. Даваахүүгийн Мягмар – Дундговь аймгийн Сайнцагаан сумын "Мандалговь-хүнс" ХХК-ийн ерөнхий захирал

31. Батсүхийн Наран – Буянт-Ухаа дахь Гаалийн газрын гаалийн улсын байцаагч

32. Дорждамбын Нина – Эрүүл мэндийн яамны Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэлгийн бага эмч

33. Арвинбуянгийн Норовцэрэн – Нийслэлийн "Хужийн гал" ХХК-ийн дэд захирал

34. Жамъяндоржийн Нэргүй – Монгол Улсын Их Хурлын хэвлэл, мэдээллийн албаны хэвлэлийн төлөөлөгч

35. Цэвээндоржийн Ням-Осор – Орхон аймгийн "Эрдэнэт-Сэлэнгэ" ХК-ийн ерөнхий захирал

36. Сандуйжавын Одхүү - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын ахлах референт

37. Жамбын Отгон - Өвөрхангай аймгийн Баянгол сумын "Баяндагналтай" ХХК-ийн захирал

38. Лудэвийн Өлзийхишиг – Техникийн их сургуулийн харьяа Уул уурхайн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

39. Дамбажавын Пүрэв – Нийслэлийн "Атар-Өргөө" ХК-ийн ажилчин

40. Цэгмидийн Ринчиндорж–Нийслэлийн "Монгео" ХК-ийн ерөнхий захирал

41. Арганы Сайлау – Баян-Өлгий аймгийн Өлгийн сумын "Шынар" хоршооны эзэн

42. Гэндэнгийн Самбалхүндэв – Нийслэлийн "Атар-Өргөө" ХК-ийн ажилчин

43. Чанцалын Сүхбаатар – Нийслэлийн "Эрдэнэ зам" төрийн өмчит үйлдвэрийн газрын дэд захирал

44. Мядагийн Тогооч - Нийслэлийн "Цамба-Хөх тэнгэр" ХХК-ийн ерөнхий инженер

45. Чулууны Төрбат – Говь-Алтай аймгийн Чандмань сумын "Түлш - Алтай" ХХК-ийн ерөнхий захирал

46. Ишээнгийн Хорчин – Хөвсгөл аймгийн "Хөвсгөл геологи" ХК-ийн Урт сайрын алтны уурхайн дарга

47. Бямбаагийн Хүүхэнхүү - Нийслэлийн Хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн "Хүнстех" корпорацийн гүйцэтгэх захирал

48. Надмидын Цэндсүрэн – Эрүүл мэндийн яамны Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэлгийн их эмч

49. Рэнцэндоржийн Цэрэндэжид – Нийслэлийн 25 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

50. Пэрэнлэйн Цэрэн-Өлзий – Замын-Үүд дэх Гаалийн газрын гаалийн улсын байцаагч

51. Зумбын Чантуу – Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Зүүнхараагийн "Спирт бал бурам" ХК-ийн спиртийн үйлдвэрийн дарга

52. Нямжавын Шагдарсүрэн – Нийслэлийн "Говь" ХК-ийн сантехникийн инженер

53. Цэндийн Шинэбаяр – Дорнод аймгийн "Найнги" ХХК-ийн захирал

54. Лувсандоржийн Эвийхүү - Төв аймгийн Сэргэлэн сумын "Гурван төхөм" ХХК-ийн захирал

55. Түмэндэмбэрэлийн Энхтуяа – Нийслэлийн "Бэнэдакт" ХХК-ийн технологич-инженер

56. Лувсанчимэдийн Эрдэнэбуд – Дундговь аймгийн Сайнцагаан сумын "Мандалговьимпекс" ХК-ийн захирал

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Сүндэвийн Батбаяр–Улсын филармоний "Баян Монгол" чуулгын хөгжимчин

2. Балжиннямын Батжаргал – Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ""Хөвсгөл" ХК-ийн машинч

3. Дамдины Батхүү - Орхон аймгийн "Монгол судар" ХК-ийн захирал

4. Ламжавын Баянжаргал – Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийн туслах ажилтан

5. Содномын Бямбасүрэн – Төв аймгийн Зуунмод сумын "Түрлэг" ХХК-ийн захирал

6. Дашдоржийн Гарваа – Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Хөвсгөл геологи" ХК-ийн ангийн дарга

7. Нямдашийн Дүгэржав – Нийслэлийн "Жуулчин" ХК-ийн жолооч

8. Содномдоржийн Зандансүрэн – Говь-Алтай аймгийн барилга угсралтын "Арвин бэлт" ХХК-ийн сантехникч

9. Данзангийн Лавдансүрэн – Ашигт малтмалын Хэрэг эрхлэх газрын харьяа геологийн мэдээллийн төвийн инженер

10. Түндэвийн Лхагвадорж – Нийслэлийн "Хүн-Од" ХХК-ийн захирал

11. Довчингийн Найдан – Нийслэлийн "Гэгээ" компани (УҮГ)-ийн слесарьч

12. Магванжавын Нямдорж – Баянхонгор аймгийн "Баянхонгоргео" ХК-ийн жолооч

13. Гаравчойжилын Төмөрхүү - Нийслэлийн "Говь" ХК-ийн арьс, шир боловсруулах үйлдвэрийн дарга

14. Хишигтийн Уламбаяр – Монгол-Оросын хамтарсан "Монголросцветмет" нэгдлийн ахлах геологич

15. Очирбатын Цогтсайхан – Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Хөвсгөл геологи" ХК-ийн жолооч

16. Дэндэвийн Цэндбазар – Нийслэлийн "Говь" ХК-ийн засварчин

17. Бадрахын Цэндсүрэн – Улаанбаатар хот дахь Гаалийн газрын гаалийн улсын байцаагч

18. Чулуунгомбын Энхтуяа – Нийслэлийн "Атар-Өргөө" ХК-ийн чанар шалгагч

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**1999 оны 12 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 216** **Улаанбаатар хот**

**Цэргийн нийтлэг дүрмүүд батлах тухай**

1. Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлийн 10 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Цэргийн дотоод албаны дүрэм, Цэргийн сахилгын дүрэм, Цэргийн хүрээний ба харуулын дүрэм, Цэргийн жагсаалын дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2. Эдгээр дүрмүүдийг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг Батлан хамгаалахын сайд /Ш. Түвдэндорж/, Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дарга /Ц. Дашзэвэг/, Хилийн цэргийн удирдах газрын дарга /Б. Базарсад/, Улсын аюулгүй байдлыг хангах газрын дарга /Ж. Энхнасан/, Дотоодын цэргийн дарга /Ч. Амарболд/ нарт үүрэг болгосугай.

3. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 1991 онны 90 дүгээр зарлигаар батлагдсан БНМАУ-ын Цэргийн дотоод албаны дүрэм, Цэргийн сахилгын дүрэм, Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрмийг хүчингүйд тооцсугай.

4. Дүрмүүдийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалах яам /Ш. Түвдэндорж/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**1999 оны 12 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 217** **Улаанбаатар хот**

**Зарим хүнийг "Шударга журам" медалиар шагнах тухай**

Эр зориг, авхаалж самбаа гарган үерийн усноас хүүхдүүдийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн дор дурьдсан хүмүүсийг "Шударга журам" медалиар шагнасугай.

1. Хоролсүрэнгийн Амарсайхан – Дорнод аймгийн Баян-Уул сумын 4 дүгээр багийн иргэн
2. Содномрашийн Батбаатар – Ниийслэлийн "Улаанбаатар" банкны мөнгө хураагч
3. Балгансүрэнгийн Батмөнх – Булган аймгийн Сэлэнгэ сумын 1 дүгээр багийн иргэн
4. Дулмаагийн Дондов – Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 5 дугаар хорооны иргэн
5. Лхагваагийн Түмэнбаяр – Архангай аймгийн Тариат сумын иргэн

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**1999 оны 12 дугаар сарын 28-ны өдөр** **Дугаар 218** **Улаанбаатар хот**

**Далелханы Есболыг "Шударга журам" медалиар нэхэн шагнах тухай**

Эр зориг, авхаалж самбаа гарган голын усанд живсэн гурван хүүхдийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын I дүгээр багийн иргэн агсан Далелханы Есболыг "Шударга журам" медалиар нэхэн шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**1999 оны 12 дугаар сарын 31-ний өдөр** **Дугаар 219** **Улаанбаатар хот**

**Зарим шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Гэрэлийн Тэгшсуурийг Дорноговь аймгийн шүүхийн ерөнхий шүүгчийн, Содномдаржаагийн Батдэлгэрийг Нийслэлийн шүүхийн ерөнхий шүүгчийн, Лувсандашийн Гансүхийг нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**1999 оны 12 дугаар сарын 31-ний өдөр** **Дугаар 220** **Улаанбаатар хот**

**Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын "Шүүхийн тухай хууль"-ийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Нийслэлийн Налайх дүүргийн шүүхэд шилжин ажиллах болсон учир Лувсандашийн Гансүхийг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр** **Дугаар 01** **Улаанбаатар хот**

**Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөр шүүхэд шилжин ажиллах болсонтой холбогдуулан Дугажийн Дамдиндоржийг Архангай аймгийн шүүхийн шүүгчийн, Цэрэннадмидын Батсүрэнг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Даваахүүгийн Мөнхтуулыг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2000 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр** **Дугаар 02** **Улаанбаатар хот**

**Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Зарлиг болгох нь:

Цэрэннадмидын Батсүрэнг Архангай аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Дугажийн Дамдиндоржийг нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Даваахүүгийн Мөнхтуулыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: "Төрийн мэдээлэл"** эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 Төрийн ордон ☎ 329612 Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх үйлдвэрт хэвлэв.
☎ 329487